



## ДЭЭД БОЛОВСРОЛД ХАМААРАХ ЭРДМИЙН ЗЭРГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ ДЭЛХИЙ ДАХИНЫ КОНВЕНЦЫГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооолоор “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна. Энэхүү урт хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтооолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон 2020 оны 24 дүгээр тогтооолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т олон улсад өрсөлдөх чадвартай боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн. “Алсын хараа- 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого хэрэгжсэнээр олон улсын болон үндэсний хөдөлмөрийн зах зээлд хүлээн зөвшөөрөгдхүйц мэдлэг, ур чадвартай, бүтээлч сэтгэлгээ, оюуны өндөр чадвартай, дасан зохицох чадвартай иргэнийг хөгжүүлэх зорилтыг тусгасан.

Энэхүү зорилтын хэрэгжилтийг хангахад дэлхийн улсуудтай боловсрол, сургалт, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх явдал чухал байр суурьтай байна. Дээд боловсролын сургалт болон эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээг тодорхойлсон баримт бичиг батлах ажил 1975 оны 6 дугаар сард Латин Америк болон Карибд дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг, цолыг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг баталснаас хойш дэлхийн бүх бүс нутгийг хамруулсан ижил төрлийн 11 конвенцыг баталсан байdag.

Монгол Улс ЮНЕСКО-гийн 1960 оны “Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай” конвенцод 1964 онд, 1989 оны “Техник болон мэргэжлийн боловсролын тухай” конвенцод 1991 онд, 1983 оны “Ази-Номхон далайн орнуудын дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан зөвшөөрөх тухай” бүс нутгийн Бангкокийн конвенцод 1991 онд тус тус нэгдэн орсон. Түүнчлэн 2011 оны “Ази, Номхон далайн орнуудын дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай” бүс нутгийн Токиогийн конвенцод 2018 онд тус тус нэгдэн орж, Засгийн газрын 2018 оны 399 дүгээр тогтооолоор Дээд боловсролын эрдмийн зэрэг хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон далайн бүс нутгийн конвенцыг баталсан.

2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар “Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахини конвенц”-ийг баталсан нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловсролыг салбарыг хамарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ болсон юм.

Энэхүү конвенц нь нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын сургалтын үр дүн, зэрэг, цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их, дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрээр суралцаж, эзэмшсэн мэргэшлээ хүлээн зөвшөөрүүлэх боломжийг олгодог.

Иймд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд энэхүү конвенцод нэгдэн орох зайлшгүй шаардлагатай байна.

### **Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

“Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахини конвенц”-ийг соёрхон батлах тухай” хуулийн төслийн зорилго нь Монгол Улс олон улсын хамтын нийгэмлэгээс авч хэрэгжүүлж буй санал, санаачилга, дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт өрнүүлэх харилцаа, хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулахад оршино.

Хуулийн төсөл нь нэг зүйлтэй байна.

Уг хуулиар дээд боловсролын байгууллагын гадаад хамтын ажиллагаа, хамтарсан хөтөлбөр, зайн сургалт, бус нутаг, дэлхий дахинд дээд боловсролын хөтөлбөрийн талаарх мэдээлэл түгээх, чанарын баталгаажуулалттай холбоотой харилцааг зохицуулна.

### **Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засаг, хууль эрх зүйн сөрөг үр дагавар үүсэхгүй бөгөөд конвенцод нэгдэн ороход эдийн засгийн ямар нэг үр дагавар, нөлөө байхгүй. Учир нь конвенцод нэгдэн орж, хэрэгжүүлэхэд ямар нэг төлбөр шаардахгүй юм. Энэхүү конвенцод нэгдэн орсноор дээд боловсролын салбар дахь олон улсын харилцан ашигтай хамтын ажиллагаа бэхжиж, бус нутаг хоорондын санал, бодлого, инновац дэмжигдэх, дээд боловсролын байгууллага, тогтолцоонд чанарын баталгаажуулалтын тогтолцоо, соёл төлөвших, чанарын баталгаажуулалт найдвартай, уялдаа холбоо, чадавх бэхжих олон талын ач холбогдолтой юм.

Хуулийн төсөл батлагдсанаар дээд боловсролын мэргэшлийг шударга, ил тод, ялгаварлан гадуурхалгүйгээр хүлээн зөвшөөрч, дээд боловсрол эзэмших боломжийг олгож, цаашдын суралцах, ажилд орох боломжийг олгодог нийтлэг зарчмууд хэрэгжинэ.

Конвенцын II дугаар зүйлд “9. Чанартай дээд боловсролыг тэгш, хуртээмжтэй эзэмших боломжийг эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх замаар хөхиүүлэн дэмжих, дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийг оролцуулан бүх хүнд насан туршийн сургалтын боломжийг бүрдүүлэн дэмжих” гэж заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-гийн Дээд боловсролын газраас өгсөн тайлбарын дагуу Монгол Улс 1951 оны баталсан “Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц” болон түүний 1967 оны

протоколд нэгдэж ороогүй нь Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахинь конвенцын VII дугаар зүйл “Дүрвэгсэд ба шилжин суурьшсан этгээдийн хамрагдсан хэсэгчилсэн сургалт ба эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх”-д харшлахгүй болно. Иймд хууль батлагдсанаар зайны сургалтаар олж авсан иргэний мэргэшил, өмнө нь суралцсан болон суралцах хугацааг хүлээн зөвшөөрөх, дүрвэгсэд болон шилжин суурьшсан иргэд насан туршийн боловсрол, сургалтад хамрагдах боломж бүрдэнэ.

Дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, цол, чанарын баталгаажуулалтын талаарх үнэн зөв мэдээллийг ил тод, хүртээмжтэй байлгах үүднээс дээд боловсролын мэдээллийг нэгтгэх, түгээх чиг үүргийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл хариуцан ажиллах бөгөөд энэ нь одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Боловсролын хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

**Дөрөв.Хуулийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, бусад хууль тогтоомжтой уялдуулан боловсруулна.

---оОо---